



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/68

Халбан

Хог цэвэрлэх, сэг зэм устгах ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, 59.1.20 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаал, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нийт нутаг дэвсгэрт зудын гамшгийн үед хорогдсон малын сэг зэмийг булшлах, шар усны үерийн аюулын үед үүссэн хохирлыг арилгах, нийтийн эзэмшлийн болон бэлчээрийн хог хаягдлын ажлыг цэвэрлэх талаар дараах ажлуудыг зохион байгуулсугай.

1.1. Дэлгэрхаан, Зуунмод, Ренчинжугнай, Уранхайрхан, Жаргалант, Бүрхээр багуудын хогийн цэгийг хумих, дарах, бөөгнүүлж овоолсон малын сэг зэмийг устгаж булшлах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг сумын Засаг даргын Орлогч (Д.Отгонбаяр), багийн Засаг дарга (Б.Даваа, Х.Билэгсайхан, Ч.Цог-Эрдэнэ, Д.Баясгалан, Н.Эрхэмбаяр, Д.Дамжинрагчаа) нарт

1.2. Сумын төвийн ойролцоох хог хаягдал, сумын нэгдсэн хогийн цэгийн хогийг түрэх, булах, цэвэрлэх ажлыг чанартай зохион байгуулахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасаг, Халбан багийн Засаг дарга (Д.Мөнх-Эрдэнэ) нарт

1.3. Сумын нэгдсэн хогийн цэг, багуудын хогийн цэг, сэг зэм устгасан талбай болон ажилласан машин техник, хүн хүч, багаж хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, зөвлөгөө өгч ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Н.Алтанхуяг)-т

1.4. Шар усны үерийн аюулын улмаас эвдэрч гэмтсэн зам, даваа, гүүр зэргийг засварлаж сэргээн босгох ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг сумын Засаг даргын Орлогч (Д.Отгонбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах төсөв санхүүгийн тооцоог хийж, холбогдох анхан шатны материалыг бүрдүүлэн "Тэсийн голын эх Булнайн нурууны байгалийн цогцолборт газар"-ын захиргаанд хүргүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын багцаас санхүүжилт авах ажлыг зохион байгуулахыг Санхүүгийн албаны дарга (Г.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

